



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 5/18

Чингис хот

Г.Нэргүйбаатарт сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1,2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймаг дахь Төрийн аудитын газраас Биеийн тамир, спортын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан тул тус газрын 2021 оны 158/A2370450 тоот албан шаардлагын дагуу Биеийн тамир, спортын газрын дарга Г.Нэргүйбаатарт үндсэн цалинг 2 сарын хугацаанд 15 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын газрын дарга Г.Нэргүйбаатарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Г.Лхагвахатан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231012379